



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 1/210

Жавхлант

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын (орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам батлах тухай) 1 дүгээр хавсралтын 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2025 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх зорилго бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Г.Энхзаяа

Засаг даргын Орлогч

Нарийн бичгийн дарга:

Т.Эрдэнэцэцэг

Санхүү албаны дарга

Гишүүдэд:

Ш.Эрдэнэзаяа

Байгаль орчны асуудал хариуцсан
Мэргэжилтэн

Ю.Болормаа


Жавхлант багийн иргэн

Г.Шижирбаатар

Тархвар зүйч

2.Багийн Иргэдийн Нийтийн Хурлын тогтоолоор ирүүлсэн саналыг нэгтгэж, чиг үүрэгт хамаарах хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээг тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлэн нэгтгэж 2025 оны 07 дугаар сард багтаан сумын Засаг даргад ирүүлэхийг Ажлын хэсгийн анхлагч (Г.Энхзаяа), Нарийн бичгийн дарга (Ш.Эрдэнэзаяа) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.БАТЧУЛУУН